

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар  
сарын 26-ны өдрийн 15 дугаар тогтоолын хавсралт



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН  
“ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН  
АРИЛЖААНЫ ЖУРАМ”**

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 28 тоот  
тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

## ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	3
1. дүгээр зүйл. Журмын зорилт .....	3
2. дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ.....	3
3. дугаар зүйл. Анхдагч зах зээлийн арилжааны арга .....	3
4. дүгээр зүйл. Арилжааны шимтгэл, хураамж.....	4
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГААР ХИЙХ АРИЛЖАА.....	4
5. дугаар зүйл. Захиалга бүртгэлийн арга ашиглах нөхцөл .....	4
6. дугаар зүйл. Захиалга бүртгэлийн ажиллагаа .....	5
7. дугаар зүйл. Үнэ тогтоох.....	5
8. дугаар зүйл. Хуваарилалт.....	6
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭ ХАЯЛЦУУЛАХ ДУУДЛАГА ХУДАЛДАА .....	7
9. дүгээр зүйл. Дуудлага худалдааны арга, ашиглах нөхцөл.....	7
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТОГТООСОН ҮНЭЭР САНАЛ БОЛГОХ АРИЛЖАА.....	7
10. дугаар зүйл. Тогтоосон үнийн түвшинд санал болгох арилжаа .....	7
ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД.....	8
11. дүгээр зүйл. Бусад .....	8
ХАВСРАЛТ 1. Анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах гэрээ .....	9

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1. дүгээр зүйл. Журмын зорилт

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Монголын хөрөнгийн бирж (цаашид МХБ гэх)-д бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгсэл, хадгаламжийн сертификат болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан бусад санхүүгийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх, арилжих үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 28 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

### 2. дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ

- 2.1 Үнэт цаасны арилжаатай холбоотой нийтлэг харилцааг МХБ-ийн “Арилжааны журам”-аар, үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 2.2 Журамд хоёрдмол утга гарсан тохиолдолд, МХБ нь журмыг тайлбарлах эрхтэй байна.

### 3. дугаар зүйл. Анхдагч зах зээлийн арилжааны арга

- 3.1 Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг дараах аргуудаар зохион байгуулна. Үүнд:
- 3.1.1 Захиалгын бүртгэлийн аргаар байршуулах арилжаа - Тодорхой хугацаанд харилцагчдын ирүүлсэн захиалгын саналд үндэслэн үнэт цаас гаргагчаас тогтоосон үнэ (өгөөж)-ээр арилжих үйл ажиллагаа;  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 3.1.2 Үнэ хаялцуулах (өгөөжөөр өрсөлдүүлэх) дуудлага арилжаа - Үнэт цаасны багцыг тогтоосон үнэ (өгөөж)-ээс эхлэн үнэ хаялцуулан (өрсөлдүүлэн) арилжих үйл ажиллагаа;  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 3.1.3 Тогтоосон үнэ (өгөөж)-ээр санал болгох арилжаа - Үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр санал болгон арилжих үйл ажиллагаа.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 3.1.4 Журмын 3.1.1-3.1.3-д заасан аргуудыг хосолсон байдлаар хэрэглэж болно.
- 3.2 Энэ журмын 3.1.1-3.1.4-д заасан аргуудын аль нэгээр анхдагч зах зээлд арилжаа явуулах тухай Санхүүгийн зохицуулах хороо (Цаашид Хороо гэх)-ны шийдвэр гарч, Хороонд бүртгүүлсэн танилцуулгад тусгасны дагуу арилжааг зохион байгуулна.
- 3.3 Үнэт цаас гаргагч, андеррайтер нь үнэт цаасны танилцуулгад арилжааны арга, стратегийн, мэргэжлийн болон жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад үнэт цаас

хуваарилах зарчим, хувь хэмжээ болон хязгаарлалтын нөхцөл байгаа тохиолдолд тус нөхцөлүүдийг тодорхой тусгасан байна.

- 3.4 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасаа 6-аас доошгүй сарын хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагчийг стратегийн хөрөнгө оруулагч гэж ойлгох бөгөөд үнэт цаасны танилцуулгад өөрөөр тусгаагүй бол андеррайтер нь үнэт цаас гаргагчтай зөвшилцсөний үндсэн дээр олон нийтэд санал болгож буй хувьцааны 50 хүртэл хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилж болно. Тухайн хөрөнгө оруулагчийг стратегийн хөрөнгө оруулагч гэж үзсэн тайлбараа хөрөнгийн бирж болон олон нийтэд мэдээлнэ.
- 3.5 Анхдагч зах зээлийн арилжааны хэлцэл биелүүлэх ажиллагааг энэхүү журмын 3.4 дүгээр зүйлд заасан нөхцөлийн дагуу андеррайтераас ирүүлсэн хүсэлт болон үнэт цаасны танилцуулгад тусгасан хуваарилалтын зарчмын дагуу МХБ гүйцэтгэнэ.
- 3.6 Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжааны захиалга авч эхлэхээс өмнө МХБ-тэй “Анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулах гэрээ” байгуулна.

#### **4. дүгээр зүйл. Арилжааны шимтгэл, хураамж**

- 4.1 Арилжааны шимтгэлийг МХБ-ийн “Арилжааны журам”-ын Хавсралт 1-д заасан аргачлалын дагуу тооцож төлүүлнэ.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГААР ХИЙХ АРИЛЖАА**

#### **5. дугаар зүйл. Захиалга бүртгэлийн арга ашиглах нөхцөл**

- 5.1 Захиалгын бүртгэлийн хугацаа эхлэхээс 7-оос доошгүй, 30-аас дээшгүй хоногийн өмнө үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд танилцуулсан байна.
- 5.2 Андеррайтер нь МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр зүйлд зааснаас гадна дараах мэдээллийг захиалга авч эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө олон нийтэд өөрийн, үнэт цаас гаргагчийн болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ. Үүнд:
  - 5.2.1 Захиалгын арга, үе шат;
  - 5.2.2 Санал болгосон дээд, доод үнэ (өгөөж) ;  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
  - 5.2.3 Андеррайтер, туслах андеррайтерийн үүрэг, хариуцлага;
  - 5.2.4 Арилжих үнэ (өгөөж)-ийг тогтоох аргачлал;  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
  - 5.2.5 Хуваарилалтын нөхцөл, үүнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгох, хуваарилах хувь хэмжээ, нөхцөл нь олон нийтэд санал болгох, хуваарилах хувь хэмжээ, нөхцөлөөс өөр байхаар Хорооноос шийдвэрлэсэн бол энэ шийдвэр;

#### 5.2.6 Хязгаарлах нөхцөл.

- 5.3 Өрийн хэрэгслийн хувьд захиалгын бүртгэлийн хугацаа эхлэхээс 3-аас доошгүй, 30-аас дээшгүй хоногийн өмнө үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд танилцуулсан байна.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

### **6. дугаар зүйл. Захиалга бүртгэлийн ажиллагаа**

- 6.1 Үнэт цаасны захиалга бүртгэлийн ажиллагааг МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжааны програмаар зохион байгуулах бөгөөд МХБ нь захиалга бүртгэлийн хугацаанд арилжааны програмд оруулсан үнэ (өгөөж)-ийн санал арилжаанд оролцогчдод харагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 6.2 Захиалгын бүртгэл нь 3-аас доошгүй, 10-аас дээшгүй ажлын өдрийн хугацаанд үргэлжилнэ. Энэ журмын 8.2 дахь заалтын дагуу санал болгосон доод болон дээд үнэ (өгөөж)-ийн хязгаарыг дахин хянах нөхцөл үүссэн тохиолдолд уг хугацааг ажлын 3 хүртэл өдрөөр сунгаж болно.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 6.3 Харилцагч захиалга бүртгэлийн хугацаанд энэ журмын 7 дугаар зүйлд заасан нөхцлийг баримтлан үнэт цаас гаргагчийн тогтоон санал болгосон дээд болон доод үнэ (өгөөж)-ийн хязгаарын хүрээнд эсхүл үнэ (өгөөж), тоо заалгүй худалдан авах нийт үнийн дүнг заасан захиалга өгч болно.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 6.4 Захиалга биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгийг дансандаа байршуулсан харилцагчийн захиалгыг анхдагч зах зээлийн захиалгын санд бүртгэнэ.

### **7. дугаар зүйл. Үнэ тогтоох**

- 7.1 Захиалгын бүртгэлийн аргын үед үнэт цаас гаргагч болон андеррайтер нь үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан, үнэт цаасны эрэлт, бусад мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн санал зэрэг тухайн үнэт цаасны олон нийтэд санал болгох үнэ тогтоохтой холбоотой мэдээлэлд үндэслэн олон нийтэд санал болгох үнийн дээд, доод хязгаарыг урьдчилан тодорхойлох бөгөөд санал болгох үнийн дээд хязгаар нь доод үнийн хязгаарыг 20 хувиар нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.
- 7.2 Үнэт цаас гаргагч захиалга бүртгэлийн хугацаанд санал болгох үнийн дээд, доод хязгаарыг 20 хүртэл хувиар өөрчилж болох бөгөөд энэ тухай (1) Хороо, МХБ-д мэдэгдэх, (2) өөрийн, МХБ-ийн болон андеррайтерийн цахим хуудсаар дамжуулан өөрчлөлтийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээнэ.

7.3 Өрийн хэрэгслийн хувьд олон нийтэд санал болгох өгөөжийн дээд, доод хязгаарыг андеррайтер болон үнэт цаас гаргагч урьдчилан тодорхойлох ба энэхүү хязгаарт өөрчлөлт орох тохиолдолд (1) Хороо, МХБ-д мэдэгдэх, (2) өөрийн, МХБ-ийн болон андеррайтерийн цахим хуудсаар дамжуулан өөрчлөлтийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээнэ. */Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 05 тоот тогтоолоор нэмэлт оруулсан./*

7.4 Захиалга хаагдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжих үнэ (өгөөж)-ийг андеррайтер, үнэт цаас гаргагч нар тухайн үнэт цаасны зах зээлийн үнэ (өгөөж)-ийн өөрчлөлтөөс үүсч болзошгүй эрсдэл, үнэт цаасны эрэлттэй холбоотой хүчин зүйлсийг бүрэн хэмжээгээр авч үзсэний үндсэн дээр хамтран тогтооно. Уг үнэ (өгөөж)-ийг тогтоохдоо тухайн үнэт цаасыг худалдан авахаар ирүүлсэн нийт захиалгын жигнэсэн дундаж үнэ (өгөөж), үнэт цаасны борлуулалтаас олохоор төлөвлөсөн хөрөнгийг бүрэн бүрдүүлэх боломжит үнэ (өгөөж), аль болох олон харилцагчдын захиалгыг биелүүлэх боломжит үнэ зэргийг харгалзана.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

## **8. дугаар зүйл. Хуваарилалт**

8.1 Харилцагчдаас хүлээн авсан үнэт цаасны нийт захиалгын тоо нь нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны тооноос илүү байх тохиолдолд үнийн ахлах (өгөөжийн хувьд буурах) дарааллыг баримтлан үнэт цаасыг арилжих нэг үнэ (өгөөж)-ийн түвшинг тогтооно.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

8.2 Үнэ (өгөөж)-ийг тогтоосны дараа тогтоосон үнэ (өгөөж) болон түүнээс дээгүүр (доогуур) үнэ (өгөөж)-ээр өгсөн захиалгуудыг цаг хугацааны дарааллаас үл хамаарч захиалсан үнэт цаасны тоонд хувь тэнцүүлэн хуваарилна.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

8.3 Үнэ (өгөөж), тоо заалгүй худалдан авах нийт үнийн дүнг заасан захиалгыг тухайн үнэт цаасыг арилжих үнэ (өгөөж)-ийн түвшинд биелүүлж, хуваарилалтыг хийнэ.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

8.4 Үнэт цаас гаргагч болон андеррайтер энэ журмын 8.3-т заасны дагуу тодорхойлогдсон арилжих үнэ (өгөөж), түүнийг тогтоосон шалтгаан, 8.1 болон 8.2-т заасан үнэт цаасны хуваарилалтын талаарх мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан Хороонд албан бичгээр хүргүүлнэ. Хорооны зөвшөөрлөөр МХБ нь үнэт цаасны нийлүүлэлтийг хийж, анхдагч зах зээлийн арилжааг явуулна.

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭ ХАЯЛЦУУЛАХ ДУУДЛАГА ХУДАЛДАА

### 9. дүгээр зүйл. Дуудлага худалдааны арга, ашиглах нөхцөл

- 9.1 Дуудлага арилжааг багц тус бүрээр явуулна.
- 9.2 Багцаар арилжих үнэт цаасны тоо ширхэг, дуудах хамгийн доод үнэ (хамгийн дээд өгөөж)-ийн саналыг үнэт цаасны танилцуулгад тодорхой тусгасан байна.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 9.3 Үнэт цаасны багцын дуудах доод үнэ (дээд өгөөж)-ийг тухайн үнэт цаасны үнэлгээг харгалзан үнэт цаас гаргагч тогтооно.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 9.4 Дуудлага арилжааны үед хэлцэл хийгдэх хүртэл үлдэж байгаа хугацааг секундээр тооцон арилжаанд оролцогчид харуулна.
- 9.5 Дуудлага арилжаа нь захиалга бүртгэх үе, дуудах үе, хэлцэл хийгдэх үе гэсэн 3 үе шаттайгаар явагдана.
- 9.6 Харилцагчийн худалдан авах захиалга бүртгэх үе нь 60 минут хүртэл хугацаанд үргэлжлэх бөгөөд энэ үед захиалгыг өөрчлөх эсхүл цуцалж болно.
- 9.7 Дуудах үе нь 40 секундын хугацаанд үргэлжилнэ. Дуудах үед шинээр захиалга оруулах, тоо ширхгийг өөрчлөх болон үнийг бууруулан (өгөөжийг өсгөн) захиалгад өөрчлөлт оруулахыг хориглох бөгөөд зөвхөн арилжааны програмд бүртгэгдсэн захиалга дуудах үед оролцон үнэ хаялцах (өгөөжөөр өрсөлдөх) эрхтэй.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 9.8 Дуудах үед үнэ (өгөөж) шинэчлэгдсэн тохиолдол бүрт дуудах үе 40 секундээс эхлэн тооцогдоно.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 9.9 Дуудах үе эхэлснээс хойш 40 секундийн хугацаанд худалдан авах захиалгын үнэ (өгөөж)-д өөрчлөлт ороогүй, эсвэл программд бүртгэгдсэн худалдан авах захиалгын үнэ (өгөөж)-д хамгийн сүүлд өөрчлөлт орсноос хойш 40 секундийн хугацаанд дахин өөрчлөлт ороогүй тохиолдолд хэлцэл хийгдэнэ.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТОГТООСОН ҮНЭЭР САНАЛ БОЛГОХ АРИЛЖАА

### 10. дугаар зүйл. Тогтоосон үнийн түвшинд санал болгох арилжаа

- 10.1 Харилцагч худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнэ (өгөөж)-ээр өгөх бөгөөд энэ аргыг ашиглах үед үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.  
*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03. дугаар сарын 26-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 10.2 Нийт харилцагчдад тэнцүү хуваарилах хөрөнгийн суурь хэмжээг тогтоож болно.
- 10.3 Нийт худалдан авах захиалгын тоо ширхэг нийт санал болгосон үнэт цаасны тоо ширхгээс илүү гарсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглан үнэт цаасны хуваарилалтыг хийнэ. Хувь тэнцүүлэх коэффициентийг олохдоо:  
$$K = C1/C2$$
  
K- Хувь тэнцүүлэх коэффициент  
C1 - Арилжихаар санал болгож буй нийт үнэт цаасны тоо C2  
- Худалдан авах захиалгад багтсан нийт үнэт цаасны тоо
- 10.4 Худалдан авах захиалга тус бүрийг хувь тэнцүүлэх коэффициентээр үржүүлж, харилцагч бүрт оногдох үнэт цаасны тоог гаргана.
- 10.5 Хувь тэнцүүлэх коэффициентээр үржүүлж гарсан тооны бутархай орон нь 0.5-аас дээш бол 1 бүхэл нэгжид, 0.5-аас доош бол 0 нэгжид шилжүүлэн тооцно.
- 10.6 Бутархай оронг бүхэл тоонд шилжүүлсний дараа хуваарилалт хийгдсэн нийт хувьцааны тоо арилжихаар санал болгож буй үнэт цаасны тооноос илүү гарсан тохиолдолд хамгийн олон ширхэг хувьцаа авах захиалга өгсөн харилцагчдын үнэт цаасны тооноос тус бүр нэг ширхгийг хасах зарчмаар арилжихаар санал болгож буй тоотой тэнцүүлнэ.
- 10.7 Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн нөхцлийн дагуу нэг харилцагчийн үнэт цаас худалдан авах захиалгын мөнгөн дүнгийн дээд хэмжээг заасан хязгаарлалтыг тогтоож болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД

### 11. дүгээр зүйл. Бусад

- 11.1 Анхдагч зах зээлийн захиалга бүртгэсэн өдөр бүр анхдагч зах зээлийн захиалгын мэдээг олон нийтэд МХБ-ийн [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудсаар дамжуулан тогтмол хүргэнэ.
- 11.2 Анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссаны дараа Хорооны зөвшөөрлөөр тухайн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.
- 11.3 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 11.4 Анхдагч зах зээлийн арилжаатай холбогдон гарсан аливаа санал гомдлыг энэхүү журам болон МХБ-ийн “Арилжааны журам” болон “Хяналт, шалгалтын журам”-ын дагуу шийдвэрлэнэ.

## ХАВСРАЛТ 1. Анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах гэрээ

БАТЛАВ. “МХБ” ТӨХК-ийн  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

БАТЛАВ. “.....” ХК-ийн  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

### АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

№:

20.... оны ... сарын... -ны өдөр  
хот

Улаанбаатар

#### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээг нэг талаас “Монголын хөрөнгийн Бирж” ТӨХК /цаашид МХБ гэх/, нөгөө талаас Андеррайтерийн компани “.....” /цаашид Андеррайтер, хамтад нь Талууд гэх/ нар хамтран ажиллахаар харилцан тохиролцож байгуулав.
- 1.2 Талууд журам зааврын дагуу үнэт цаасыг зах зээлд байршуулах, олон нийтэд санал болгон арилжих, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаас гаргагч компанийн эрх, үүргийг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор хамтран ажиллана.
- 1.3 Талууд хамтын ажиллагаандаа “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Компанийн тухай хууль”, “Иргэний хууль”, тэдгээрт нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хороо /цаашид СЗХ гэх/, МХБ-ээс баталсан журам, заавар болон энэхүү гэрээг дагаж мөрдөнө.
- 1.4 Холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд болон талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 1.5 Гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжиж дуусах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

#### Хоёр. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Бирж нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 2.1.1 МХБ нь анхдагч зах зээлийн арилжааны нийт үнийн дүнгээс шимтгэл тооцон авах;
- 2.1.2 Үнэт цаас гаргагчаас санал болгосон арилжааны хуваарийг хянан үзэж, өөрчлөхөөр бол саналаа хүргүүлэх;
- 2.1.3 Арилжаатай холбоотой нэмэлт мэдээллийг үнэт цаас гаргагчаас гаргуулан авах;
- 2.1.4 Арилжааны явцад хяналт тавьж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах;

2.2 Бирж нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 2.2.1 Анхдагч зах зээлийн арилжааг явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, нэгдсэн сүлжээ, программ хангамжийн найдвартай байдлыг хангах;
- 2.2.2 Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн захиалгын дагуу арилжааг зохион байгуулж явуулах;

- 2.2.3 Анхдагч зах зээлийн арилжааны талаарх нэгдсэн мэдээллийг СЗХ-д хүргүүлэх;
- 2.2.4 Анхдагч зах зээлийн арилжаатай холбоотой нийтэд тараагдаагүй мэдээллийн нууцыг хадгалах;
- 2.2.5 Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн үнэт цаасны танилцуулгыг МХБ-ийн вэб хуудсанд байршуулах;

2.3 Андеррайтер нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 2.3.1 Үнэт цаасны арилжаатай холбогдолтой нийтэд тараагдах мэдээ, мэдээллийг гаргуулан авах;
- 2.3.2 Үнэт цаасны танилцуулга, үнэт цаас арилжих, хуваарилах дэлгэрэнгүй нөхцөлийг МХБ-ийн вэб хуудсанд байршуулах;
- 2.3.3 Арилжааг амжилттай зохион байгуулахтай холбоотой хууль, журамд нийцсэн саналыг МХБ-д хандан гаргах, МХБ-тэй хамтран ажиллах;

2.4 Андеррайтер нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 2.4.1 “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомж, МХБ-ийн журам, зааврыг чанд мөрдөх;
- 2.4.2 Үнэт цаасыг МХБ-ээр дамжуулан анхдагч зах зээлд арилжих тухай хүсэлтийг үнэт цаасны танилцуулгын хамт МХБ-д ирүүлэх;
- 2.4.3 Анхдагч зах зээлийн арилжаа эхлэх (эсвэл захиалга авах) өдрийг товлож, арилжаа эхлэхээс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө МХБ-д мэдэгдэх;
- 2.4.4 Тухайн үнэт цаасны арилжаатай холбоотой, танилцуулгад тусгагдаагүй бусад дэлгэрэнгүй мэдээллийг МХБ-д ирүүлэх;
- 2.4.5 МХБ-ийн “Арилжааны журам”-ын “Хавсралт 1” –д заасны дагуу анхдагч зах зээлийн арилжааны нийт үнийн дүнгээс шимтгэл төлөх;
- 2.4.6 Гаргасан хувьцааны тодорхой хэсгийг андеррайтерийн компани худалдан авахаар гэрээ байгуулсан бол үнэт цаас гаргагч болон андеррайтерийн компанийн хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний эх хувийг МХБ-д ирүүлсэн байх;

Гурав. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 3.1 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба шийдвэрлэх боломжгүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.
- 3.2 Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал хариуцна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“МХБ” ТӨХК-ийг төлөөлөн  
 төлөөлөн  
 Гүйцэтгэх захирал

“.....” ХК-ийг  
 Гүйцэтгэх захирал

.....

.....

/ ..... /

/.....